



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 462

Мандатгүй

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 03 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Баянжаргалан, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Гурвансайхан, Өндөршил, Дэрэн сумдын нутагт 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдрөөс гарсан малын гоц халдварт "Шүлхий" өвчиний үед хорио цээрийн дэглэм тогтоож сахиулах, шаардагдах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, малчид, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж ажиллахад аймгийн ЗДТГ, агентлагуудаас зарцуулсан зардалыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Уг арга хэмжээнд зарцуулсан 6,961,380.00 /зургаан сая есөн зуун жаран нэгэн мянга гурван зуун наян/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Тамгын газрын дарга /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Д.Нандинцэцэг/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200202